



ЦЭВЭР АГААР САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.БААСАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.19 № 1/144

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг
эрчимжүүлэх тухай

“Цэвэр агаарын сангийн 2011-2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт”-д аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

“Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхүүдэд цахилгаан халаагуур нийлүүлэх” тендэрт “Хөвсгөл аяны жолоо” ХХК 75 айл өрхөд цахилгаан халаагуур 150 сая төгрөгөөр нийлүүлж, суурилуулах ажилд шалгарч, 2013 оны 6 дугаар сарын 25-ны дотор хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулжээ.

“Хөвсгөл аяны жолоо” ХХК нь 2013 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хооронд нийт 20 айл өрхөд цахилгаан халаагуурыг суурилуулж, санхүүжилтийн 50 хувийг авсан боловч нийт ажлын 27 хувийг л хийж гүйцэтгэсэн байна.

Мөн гэрээ дууссанаас хойш 6 сарын хугацаа өнгөрөөд байхад уг гэрээний хугацааг сунгаагүй, Цэвэр агаарын сангаас айлуудын нэрсийг гүйцэтгэгчид бүрэн хүргүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2-т “аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгч байна.

БОАЖСайдын 2012 оны А-132 дугаар тушаалаар батлагдсан дээрх төсөл, арга хэмжээний гэрээт хугацаа дуусгавар болсон, ажлын гүйцэтгэл хангалтгүй байгаад дүгнэлт хийж, олгосон санхүүжилттэй дүйцэхүйц ажлыг гүйцэтгүүлэн суурилуулах арга хэмжээг зохион байгуулж, гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллан, 2014 оны 3 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор хариу мэдэгдэхийг Цэвэр агаар сангийн Гүйцэтгэх захирал Д.Баасан, “Хөвсгөл аяны жолоо” ХХК-ийн захирал С.Энхболд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

АУДИТОР

УХА0122

Э.УЯНГА